



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/553

Баруун-Урт сум

Дотоод аудитын хорооны гишүүдийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 4 дүгээр зүйлийн 4.12, 4.13 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийг шинэчлэн батлах тухай 29 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Дотоод аудитын хороог дараах гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Гишүүд:	Т.Цэрэгбаяр	- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга
	Х.Энхцэцэг	- Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	Д.Ариунжаргал	- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	С.Баянмөнх	- Төрийн албаны зөвлөлийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
	О.Цагаан	- Монголын мэргэшсэн нягтлан бодох институтийн Сүхбаатар салбарын гишүүн
	З.Далантай	- Баруун-Урт сумын иргэн (Төр захиргааны ахмад ажилтан)
Нарийн бичиг:	Б.Уянганям	- Дотоод аудитор

2. Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж батлуулах, хурлыг зохион байгуулах, хурлаас гарах шийдвэрийг

2223011244

албажуулах болон бусад ажлыг Дотоод аудитын хорооны дүрмийн 5.2-т заасны дагуу ажиллахыг Нарийн бичиг (Б.Уянганям)-т үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын хорооны дүрмийг мөрдөж ажиллахыг Дотоод аудитын хорооны бүх гишүүдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Дотоод аудитын хорооны гишүүдийг шинэчлэн томилох тухай" аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/333 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ